



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 11 сарын 11 өдөр

Дугаар А/211

Улаанбаатар хот

Зайлшгүй шаардлагатай эмийн 10 дугаар
жагсаалтын төслийг боловсруулах ажлын хэсгийг
шинэчлэн байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.9, 6.3, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/295 дугаар тушаалын 2 дугаар хавсралт “Эм, эмийн түүхий эд, оношлуур, биологийн идэвхт бүтээгдэхүүний бүртгэлийн төлбөр зардлын жишиг зарцуулах журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын дэд дарга нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу Эрүүл мэндийн сайдын 2022 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн “Ажлаас чөлөөлөх тушаалаар чөлөөлөх тухай” Б/54 дүгээр тушаалаар чөлөөлөгдсөн тул дэлхийн эрүүл мэндийн байгууллагын ХХII жагсаалттай дүйцүүлэн зайлшгүй шаардлагатай эмийн Х жагсаалтыг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Зайлшгүй шаардлагатай эмийн Х жагсаалтыг боловсруулж 2022 оны 12 дугаар сард багтаан Хүний эмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхийг ажлын хэсгийн дарга (П.Цэцгээ)-д даалгасугай.


3. Зайлшгүй шаардлагатай эмийн Х жагсаалтыг боловсруулах ажлын гишүүдийн урамшууллыг гүйцэтгэлээр тооцож олгохыг Санхүү, төсвийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн (А.Болор-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

4. Тус ажлын хэсэгт орсон Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын албан хаагчдад илүү цагаар ажилласан хөлсийг Хөдөлмөрийн тухай хууль болон зохих журмын дагуу тооцож олгохыг Санхүү, төсвийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн (А.Болор-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Л.Батзориг)-т үүрэг даалгасугай.

6. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/116 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА




Д.НАРАНТУЯА

1422

01211

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт,
зохицуулалтын газрын даргын 2022 оны 11
дугаар сарын 11-ны өдрийн 1131 дугаар
тушаалын хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга: Эмийн аюулгүй байдлын тандалт
судалгааны газрын дарга

Ажлын хэсгийн дэд дарга: Д.Нарантунгалаг (Анагаах ухааны доктор,
дэд профессор, Эм судлалын салбар
зөвлөлийн дарга, зөвшилцсөнөөр)

Гишүүд: Эм шинжлэх лабораторийн дарга
Эмийн чанар, аюулгүй байдлын тандалт
судалгааны асуудал хариуцсан ахлах
мэргэжилтэн

Эм, эмнэлгийн хэрэгслийн үнэ, худалдан
авах ажиллагааны мэдээний сангийн
асуудал хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж
үйлчилгээний газрын эмнэлгийн тусламжийн
чанар аюулгүй байдлын хэлтсийн ахлах
шинжээч

Д.Энхжаргал (Эм зүйн ухааны доктор,
профессор, Эм зүй, эм
судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн
дарга, зөвшилцсөнөөр)

Х.Даариймаа (Эм зүйн ухааны доктор, дэд
профессор, Анагаахын шинжлэх ухааны
үндэсний их сургууль, Эм зүйн сургууль, Эм
зүй, эм судлалын мэргэжлийн салбар
зөвлөлийн нарийн бичгийн дарга
зөвшилцсөнөөр)

С.Мөнхбат (Эм зүйн ухааны доктор, дэд
профессор, Эм судлалын салбар зөвлөлийн
гишүүн, зөвшилцсөнөөр)

М.Эрдэнэтуяа (Анагаах ухааны доктор, дэд
профессор, Эм судлалын салбар зөвлөлийн
гишүүн, зөвшилцсөнөөр)

П.Батхуяг (Анагаах ухааны доктор,
профессор, зөвшилцсөнөөр)

М.Уранчимэг (Анагаах ухааны доктор, дэд профессор, Шинэ анагаах ухааны их сургуулийн Эмзүйн сургуулийн захирал, зөвшилцсөнөөр)

Н.Халиун (Анагаах ухааны доктор, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, Био-Анагаахын сургуулийн Эм судлалын тэнхим, зөвшилцсөнөөр)

С.Сарнай (Анагаах ухааны докторант, зөвшилцсөнөөр)

Б.Баярболд (Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Бодлого, төлөвлөлийн газрын Тусламж үйлчилгээний багц зохицуулалтын хэлтсийн дарга)

Ш.Сэлэнгэ (Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Бодлого, төлөвлөлийн газрын Тусламж үйлчилгээний багц зохицуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Н.Мөнгөнзагас (Эм зүйн ухааны магистр, Эм холбооны төлөөлөл, зөвшилцсөнөөр)

Нарийн бичгийн дарга:

Эмийн сонголтын асуудал хариуцсан мэргэжилтэн